



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/894

Улаанбаатар хот

Инженерийн баг,  
хяналтын инженер томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалт, ИНД-171.79.(а). 6.2 "Байгууламжийг суурилуулах ба ажилд хүлээн авах журам"-ын 6.2.4.1, 6.2.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглагддаг агаар-газрын алсын удирдлагатай хэт өндөр давтамжийн UND126.0MHz болон UND126.5MHz радиостанц /RCAG/-уудын яриа хоорондоо нөлөөлж байгаа тул, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах, агаар-газрын радио холбооны найдвартай ажиллагааг дээшлүүлж нөлөөг арилгах зорилгоор, Увс аймгийн "Дэглий цагаан" нисэх буудлаас PAE T6 маркийн алсын удирдлагатай хэт өндөр давтамжийн радиостанцыг Хэнтий аймгийн Бор-Өндөр ажиглалтын байранд шилжүүлэн суурилуулах ажлыг 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсүгэй.

2. Агаар-газрын алсын удирдлагатай хэт өндөр давтамжийн станц /RCAG/-ыг шилжүүлэн суурилуулах ажлыг хийж гүйцэтгэх инженерийн баг, хяналтын инженерийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Инженерийн багийн

ахлагч:	Д.Оюунболд	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн ахлагч инженер
Гишүүд:	Б.Төмөрбаатар	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн ахлах инженер
	Б.Булган	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн ахлах инженер
	О.Төрболд	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер

	Э.Даваасамбуу	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер
	Ж.Болорчимэг	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер
	Б.Даш-Өлзий	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн инженер
	Ж.Батжаргал	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Радио холбооны тасгийн антенны техникч
Хяналтын инженер:	Э.Төрбаяр	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн дарга

3. Тоног төхөөрөмжийг шилжүүлэн суурилуулах ажлыг агаарын навигацийн байгууламжуудын хэвийн ажиллагаанд нөлөөлөлгүй, нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангахаар зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөн ажиллахыг /Инженерийн багийн ахлагч/-д, суурилуултын ажлын явц болон гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба /Д.Баяртогтох/-нд үүрэг болгосугай.

4. Тоног төхөөрөмжийг шилжүүлэн суурилуулах, ашиглалтад оруулахтай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу гарган зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН